

“АХМАДЫН ХОТХОН-1” ОНӨААТҮГ-ААС 2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН НОГООН ХӨГЖИЛ, АГААРЫН БОХИРДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ОРЛОГЧИЙН ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ

2019.01.18

№	Товч агуулга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлт
1	<p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/01 дүгээр захирамжаар “2019 оныг “Иргэдийн оролцоотой – Хөгжлийн жил болгон зарлах тухай” болгосонтой холбогдуулан хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг иргэн, төр хувийн хэвшлийн байгууллагын саналыг тусган боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах. /НЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, /Захирамжийн хэрэгжилтийг Нутгийн захиргааны нийт байгууллагууд хангаж ажиллах/</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст 2019.01.14-ны өдрийн 15 дугаартай албан тоотоор “Иргэдийн оролцоотой хөгжлийн жил” –ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хүргүүлсэн. Биелэлт-90%</p>
2	<p>Хөрөнгө оруулалтаар 2018 онд баригдаж ашиглалтад орсон барилга байгууламж, объектуудыг нийслэлийн өмчид бүртгэж авах, ашиглалт хамгаалтыг сайжруулж ажиллах, 2019 онд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын газар чөлөөлөх ажлын бэлтгэл ажлыг хангах. /Нийслэлийн Өмчийн харилцааны газар, Эрх шилжсэн байгууллагууд, нийслэлийн Газрын алба, Дүүргийн Засаг дарга нар/</p>	<p>Нийслэлийн хөрөнгө оруулалтаар 2018 онд баригдаж ашиглалтад оруулсан Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо 21 дүгээр хороолол 63/1, 63/2 дугаар байрыг нийслэлийн Засаг даргын 2018.11.20-ны өдрийн А/1090 дугаартай захирамжаар, нийслэлийн Гэр хорооллын дэд бүтцийн газрын эзэмшлийн Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хорооны гутаг дэвсгэрт шинээр ашиглалтанд орсон 814 дүгээр байрыг нийслэлийн Засаг даргын 2019.01.08-ны өдрийн А/13 дугаар захирамжийн дагуу ашиглалт үйлчилгээг тус тус хариуцан оршин суугчдад орон сууц эзэмших эрхийн бичиг, гэрээний дагуу оруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна Биелэлт-90%</p>
3	<p>Нийслэлийн дүүргүүд, хэрэгжүүлэгч агентлагууд, Улаанбаатар хотын Захирагчийн харьяа газрууд болон нийслэлийн өмчит үйлдвэрийн газрууд, нийслэлийн төсөвт байгууллагуудын 2018 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг зохион байгуулах. /Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нутгийн захиргааны нийт байгууллагууд/</p>	<p>Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/09 тоот захирамжаар томилогдсон шалгалтын А.Даваажаргал даргатай ажлын хэсэгт 2019.01.09-ны өдөр байгууллагын 2018 оны ажлыг үнэн зөв ажлаа бүрэн тайлагнаж үнэлж дүгнүүлсэн. Биелэлт-100%</p>

ХЯНАСАН:  Г.ЧУЛУУНБААТАР
 ДУЛААНЫ ИНЖЕНЕР
 БОЛОВСРУУЛСАН:  Г.БААТАРХҮҮ
 ГЭРЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН